

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хар нуур-Ховд голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/08/НА/-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Аудитор: У.Батчимэг Утас: 70432545 цахим хаяг:batchimeg.urt@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	10
4. Аудитын илрүүлэлт	11
4.1 Залруулсан алдаа	11
4.2 Зөвлөмж	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ДБХС	Дэлхийн байгаль хамгаалах сан

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	18,509,152.00	4,605,850.00
35	БАРАА МАТЕРИАЛ	18,409,152.00	4,605,850.00
351	Түүхий эд материал	14,294,602.00	1,454,750.00
35110	Тусгай зориулалттай материал	14,294,602.00	1,454,750.00
354	Хангамжийн материал	4,114,550.00	3,151,100.00
35410	Бичиг хэргийн материал	78,000.00	350,200.00
35420	Аж ахуйн материал	3,965,650.00	2,360,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	370,000.00
35470	Бусад хангамжийн материал	70,900.00	70,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,500,608.01	6,692,573.78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,500,608.01	6,692,573.78
392	Биет хөрөнгө	7,500,608.01	6,692,573.78
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,459,500.00	30,459,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-28,663,291.68	-29,316,458.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	31,031,758.00	15,194,594.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-30,781,469.33	-13,722,127.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,770,451.84	13,770,451.84
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,316,340.82	-9,693,386.30
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	26,009,760.01	11,298,423.78
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	150,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	150,000.00
413	Өглөг	00.00	150,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	150,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	26,009,760.01	11,148,423.78
51	Засгийн газрын хувь оролцоо	26,009,760.01	11,148,423.78
512	Хуримтлагдсан үр дүн	26,009,760.01	11,148,423.78
51210	Өмнөх үеийн үр дүн	26,009,760.01	26,009,760.01
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-14,861,336.23
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	26,009,760.01	11,298,423.78

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	190,604,246.00	184,657,744.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,965,500.00	2,939,544.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,965,500.00	2,939,544.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,965,500.00	2,939,544.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,959,500.00	2,939,544.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	188,638,746.00	181,718,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	156,895,100.00	148,776,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	156,895,100.00	148,776,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,743,646.00	32,942,100.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	31,029,360.00	29,542,100.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,400,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	178,085,528.67	199,519,080.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	178,085,528.67	199,519,080.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	177,665,028.67	199,518,680.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	113,069,346.27	110,113,800.00
210101	Үндсэн цалин	76,259,029.84	77,573,300.00
210102	Нэмэгдэл	28,470,035.00	18,593,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,340,281.43	13,947,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,528,071.63	14,831,600.00
210201	Тэтгэврийн даатгал	9,727,305.00	10,437,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,122,117.00	1,098,600.00
210203	ҮОМШО-ний даатгал	897,163.00	878,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	293,185.00	219,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,488,301.63	2,197,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	453,730.00	445,500.00
210304	Байрны түрээс	453,730.00	445,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,345,200.00	30,209,602.00
210401	Бичиг хэрэг	3,063,500.00	3,100,550.00
210402	Тээвэр, шатахуун	9,139,500.00	8,537,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	875,500.00	1,790,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,266,700.00	16,781,702.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,606,646.00	13,833,000.00
210604	Урсгал засвар	6,606,646.00	13,833,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,172,500.00	13,911,600.00
210702	Дотоод албан томилолт	3,172,500.00	13,911,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,469,746.10	10,727,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,902,946.10	10,160,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	148,500.00	148,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	69,300.00	69,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.00	79,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	19,800.00	19,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,019,788.67	5,446,578.23
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,644,888.67	5,446,578.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	420,500.00	400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	420,500.00	400.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	420,500.00	400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	12,518,717.33	-14,861,336.23
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	12,518,717.33	-14,861,336.23

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
С08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	26,009,760.01	26,009,760.01

D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	26,009,760.01	26,009,760.01
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	26,009,760.01	26,009,760.01
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-14,861,336.23	-14,861,336.23
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	11,148,423.78	11,148,423.78

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	188,644,746.00	181,718,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	188,638,746.00	181,718,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	156,895,100.00	148,776,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	156,895,100.00	148,776,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,743,646.00	32,942,100.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	31,029,360.00	29,542,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,400,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	188,644,746.00	180,019,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	188,644,746.00	180,019,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	188,224,246.00	180,018,800.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	113,363,800.00	109,863,800.00
210101	Үндсэн цалин	74,844,300.00	77,323,300.00
210102	Нэмэгдэл	30,172,200.00	18,593,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,347,300.00	13,947,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,269,100.00	14,831,600.00
210201	Тэтгэврийн даатгал	10,734,600.00	10,437,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,133,600.00	1,098,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	906,900.00	878,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	226,700.00	219,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,267,300.00	2,197,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	445,500.00	445,500.00
210304	Байрны түрээс	445,500.00	445,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,500,660.00	25,691,500.00
210401	Бичиг хэрэг	3,204,300.00	2,133,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,165,200.00	8,084,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,482,700.00	2,370,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,648,460.00	13,104,200.00
2105	Нормативт зардал	356,400.00	521,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	356,400.00	521,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,097,200.00	2,379,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	178,200.00	178,200.00
210604	Урсгал засвар	2,919,000.00	2,201,000.00
2107	Томиллолт, зочны зардал	3,172,500.00	15,147,200.00
210702	Дотоод албан томиллолт	3,172,500.00	15,147,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,882,500.00	10,727,000.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,315,700.00	10,160,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	148,500.00	148,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	69,300.00	69,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.00	79,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,136,586.00	411,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,935,586.00	411,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	420,500.00	400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	420,500.00	400.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	420,500.00	400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	1,699,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	1,699,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	1,699,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	1,699,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	1,699,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-1,699,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	148,776,100	148,776,100
21	УРСГАЛ ЗАРДАЛ	148,776,100	148,776,100
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	148,776,100	148,776,100
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	109,863,800	109,863,800
210101	Үндсэн цалин	77,323,300	77,323,300
210102	Нэмэгдэл	18,593,200	18,593,200
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,947,300	13,947,300
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,831,600	14,831,600
210201	Тэтгэврийн даатгал	10,437,100	10,437,100
210202	Тэтгэмжийн даатгал	1,098,600	1,098,600
210203	ҮОМШӨ-ний даатгал	878,900	878,900
210204	Ажилгүйдлийн даатгал	219,700	219,700
210205	Эрүүл мэндийн даатгал	2,197,300	2,197,300
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	445,500	445,500
210304	Байрны түрээс	445,500	445,500
2104	Хангамж, бараа материалын зардал	7,774,000	7,774,000
210401	Бичиг хэрэг	1,179,200	1,179,200
210402	Тээвэр, шатахуун	3,713,300	3,713,300
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,260,300	1,260,300
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,621,200	1,621,200

2105	Нормативт зардал	356,400	356,400
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	356,400	356,400
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,178,200	3,178,200
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	178,200	178,200
210604	Урсгал засвар	3,000,000	3,000,000
2107	Томилолт, зочны зардал	2,738,000	2,738,000
210702	Дотоод албан томилолт	2,738,000	2,738,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,477,000	9,477,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,910,200	8,910,200
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	148,500	148,500
210803	Даатгалын үйлчилгээ	69,300	69,300
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,200	79,200
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800	19,800
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000	250,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,600	111,600
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	111,600	111,600
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	148,776,100	148,776,100
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	148,776,100	148,776,100
131001	Улсын төсвөөс санхүүжих	148,776,100	148,776,100
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	09	09
620001	Удирдах ажилтан	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	07	07
620003	Үйлчлэх ажилтан	01	01

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,743,646	32,941,700
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,743,646	32,941,700
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,743,646	32,941,700
2104	Хангамж, бараа материалын зардал	16,277,160	17,917,500
210401	Бичиг хэрэг	770,000	953,800
210402	Тээвэр, шатахуун	2,067,700	4,370,700
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,110,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,439,460	11,483,000
2105	Нормативт зардал		165,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		165,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		900,000
210604	Урсгал засвар		900,000
2107	Томилолт, зочны зардал		12,409,200
210702	Дотоод албан томилолт		12,409,200
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,250,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	405,500	1,250,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		300,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,859,986	300,000
		11,201,000	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	31,743,646	32,941,700
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,743,646	32,941,700
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	31,029,360	29,541,700

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	714,286	3,400,000
--------	--	---------	-----------

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хар нуур-Ховд голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хэмнэлтийн тогтоолыг мөрдөх талаар зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор У.Батчимэг 2022 оны 02 дугаар сарын 10-наас 2022 оны 02 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хар нуур-Ховд голын сав газрын захиргааны үйл ажиллагааны эрхэм зорилго нь салбарын бодлогыг оновчтой хэрэгжүүлэх замаар “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон усны зохистой ашиглалт хамгаалалтыг бий болгох замаар сав газрын нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах” гэсэн зорилгын дор үйл ажиллагааны явуулжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх талаар дараах тогтоолд өөрчлөлт орсон байна.

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хар нуур-Ховд голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 180.0 сая 2 хувиар тооцон 3.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.8 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хар нуур-Ховд голын сав газрын захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8.6 сая төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 18.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл нь 4.6 сая төгрөг 13.8 сая төгрөгөөр буюу 25 хувиар өссөн байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 26.3 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, 27.2 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 7.5 сая төгрөг байсан бол оны эцэст 6.6 төгрөг болж 0.8 сая төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдэлтэй холбоотой байна. Тайлант онд 1.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, 12.4 сая төгрөгийн хөрөнгө акталж устгасан байна. Тайлант оны эцэст 6.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд 0.15 сая төгрөгөөр өр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 26.0 сая төгрөг байсан ба оны эцэст 11.4 сая төгрөг болж 14.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 14.8 сая төгрөгийн алдагдал нөлөөлсөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 148.7 сая төгрөгөөр, нийт зарлагыг 148.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас тус байгууллагын төсвийг 148.7 сая мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 148.7 сая төгрөгийн төсөв баталснаас 148.7 сая төгрөгийг улсын төсвөөс зардалд санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 148.7 сая төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар ДБХС-аас 29.5 сая төгрөгийн санхүүжилт, үйл ажиллагааны орлого 3.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж нийт 32.9 сая төгрөгийн орлого бүрдүүлэн ажиллажээ.

Нэмэлт төсвийн тайланг энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 147 мэдээллээс 147 хугацаандаа оруулсан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын тухай бүр шилэн дансны цахим хуудсанд байршуулсан илгээсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 0.15 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар цалингийн урьдчилгааг илүү суутган бүртгэсэн тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгалаа. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайланд залруулга хийлгэн цалингийн өглөгт тусган тайлант үеийн үр дүнгийн зардлыг залруулав.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 0.15 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан тайланг албан тоотыг тухайн байгууллага ирүүлсэн болно.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4.1 Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бэлтгэн нийлүүлэгчээс бараа материал худалдан авахдаа И төлбөрийн баримтаар бүрэн гүйцэд баталгаажуулаагүй.

Өгсөн зөвлөмж: "Татварын ерөнхий хуулийн 28.5.Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" заалтыг мөрдөн И баримтаар гүйлгээ хийж хэвших.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хар нуур-Ховд голын сав газрын захиргаа	1	0.15	1	0.15			0	0	1	0

АУДИТЫН ТАЙЛАНГ-ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ-БИЧСЭН

АУДИТОР:

У.БАТЧИМЭГ

